

2016 оны санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайлан

Чойбалсан хот

2017.02.03

"Дорнод Авто зам" Хувьцаат компани нь аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа улсын чанартай 1250 км авто замын арчлалтын хариуцан гүйцэтгэдэг бөгөөд эдгээр замууд нь ОХУ,БНХАУ-тай 7 чиглэлээр холбогддог, улс хоорондын авто замын тээвэрт чухал үүрэг ач холбогдолтой. Халхгол,Нөмрөг,Хэрлэн,Улзын голын нийт 5 бетон хийц бүхий гүүрүүдийн арчлалт хамгаалалтын ажлыг 5 гүүр хамгаалагч хариуцан ажиллаж байна.

"Дорнод Авто зам" Хувьцаат компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 74922 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 7,5 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй.Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй бөгөөд 3 гишүүн нь хараат бус гишүүд ажилладаг.

Манай компани нь 2016 онд 501.2 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 463.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 31.8 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч өмнөх онд 51,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан учраас энэ оны санхүүгийн тайлангаар хуримтлагдсан ашгийн зөрүү тайлант үе, өмнөх үеийн зөрүүний өссөн дүнгээр 19,4 сая төгрөгийн алдагдалтай гарсан. Тайлант онд Зам,Тээврийн Хөгжлийн Яамтай хийсэн гэрээний дагуу улсын чанартай зам засвар арчлалтын ажлуудыг гэрээний дагуу бүрэн хийж гүйцэтгэв.

Компани дээрхи ажлуудыг хийж гүйцэтгэхдээ 25 ажиллагсадтайгаар зам засвар арчлалтын ажилд ажиллаж, цалингийн зардалд 97,3 сая төгрөг,НДШимтгэлд 12,7 сая төгрөг, материал түүхий эд худалдан сэлбэг хэрэгсэл болон шатахуунызэрэг шүд үйлдвэрлэлийн зардалд 360,0гаруй сая төгрөгийг зарцуулав. Мөн НӨАТатварт 60,0 сая төгрөг,бусад тавар шимтгэлд 15,6 сая төгрөгийн татвар төлөлтийг тооцож аймаг орон нутгийн татварт төвлөрүүлэн ажиллав.ХААН банкнаас 150,0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа тасралтгүй жигд явуулан, зээлийн эргэн төлөлт 100,0 сая төгрөгийг барагдуулан ажилласан. 2016 оны санхүүгийн тайлангаар 7,0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, хувь хүн, татвар шимтгэлийн 2763,8 мянган төгрөгийн авлагатай, 454,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 248,6 сая төгрөг байна.НӨАТатварт 724,0 мянган төгрөг, банкны зээлэнд 50,0 сая төгрөг, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд баталгаажигдаагүй 9,2 хувь буюу 6893 ширхэг хувьцаанд ноогдох 944,3 мянган төгрөгийн ноогдол ашгийн өр төлбөр тайланд тусгагдсан.

Аймгийн Татварын албаны төлөвлөгөөт шалгалтанд хамрагдан 2013-2015 оны санхүүгийн үйл ажиллагаагаа шалгуулж, 1,4 сая төгрөгийн хүү торгуулийг төлж барагдуулав.Компани алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

2016 онд зам засвар арчлалтын ажилд 32,5 сая төгрөгийн үнэ бүхий 25 тн-ийн чирэгч трайллер худалдан авсан ба автогрейдер машин түрээслэн ажиллав. Машин техникийн хүрэлцээгүй,хуучин машин,механизмаар ажил гүйцэтгэхэд ажлын шаардлага хангахгүй байдлаас шалтгаалан гаднын компаниас шаардлагатай машин механизм түрээслэн авч ажиллуулснаар графикт ажлуудыг хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

Ажилчдын нийгмийн идэвхийг сайжруулах,тэдний чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор ажиллагсадынхаа дунд зохион байгуулсан уралдаан, биеийн тамирын тэмцээнүүдэд нийт ажиллагсад идэвхтэй оролцож,цаашид жил бүр тогтмол зохион байгуулж байна. Машин техникийн бүрэн бүтэн байдал,ажилд байнга бэлэн байх зорилгоор парк зохион байгуулалтанд орж,тосолгоо арчилгааг тогтмол хийж хэвшиж байна.Хээрийн бригад ажиллагсдад хээрийн нэмэгдлийг тогтмол олгож, бригадын байрлах вагон орон сууц болон Хөлөнбуйр, Баян уул сумдад байрлах объектын барилга,гэрийг сэргээн засварлалаа.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг НББОУС-ын дагуу хөтлөн, баланс,орлого үр дүнгийн тайлан,өмчийн өөрчлөлтийн тайлан,мөнгөн гүйлгээний тайлан,бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланг бэлтгэн компанийн удирдлагыг санхүүгийн иж бүрэн мэдээлэлээр ханган ажиллаж байна.

Тайлан бичсэн:

“Дорнод Авто зам” Хувьцаат компанийн

Нягтлан бодогч



Ц.ОТГОН